



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/661

Булган сум

### Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 61.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ж.Ганболд нь ходоодны хорт хавдрын улмаас Бүгд найрамдах Солонгос улсын “Сон-Э” эмнэлэгт яаралтай мэс засалд орж, хэвтэн эмчлүүлж байгаа тул 15,000,000 (арван таван сая) төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

2. Буцалтгүй тусламжийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.



ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ